

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 357 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн “Ховд дулааны станц” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт байгууллагын батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Ховд дулааны станц” ТӨХК (Д.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 174 дүгээр тогтоолын хавсралтын 1 дэх хэсгийн 1,2,5 дугаар мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 3-8 дугаар мөрөнд заасан Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

**ХОВД АЙМГИЙН “ХОВД ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Ховд аймгийн Жаргалант сумын “Ховд дулааны станц” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	3,380.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 38,617.0
		Тогтмол	Төг/м <sup>3</sup> 2,362.0
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	2,430.0
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 27,770.0
		Тогтмол	Төг/м <sup>3</sup> 1,698.3
5	Төсөв, ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	4,000.0
6	Орон сууцны халаалт (дотуур байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	1,400.0
7	Орон сууцны хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 9,142.3
		Тогтмол	Төг/м <sup>3</sup> 559.2
8	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	3,750.0
		Төг/хүн	9,000.0